



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Г “Монгол секюритиес УЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тогтоо

Ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалтууд, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дүгээр тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих” журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 10.00 цагт Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг 15 хороо, Гэгээнтэн цогцолбор 215 тоотод хуралдуулахаар тогтоосугай.
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар доор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
  - Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат гишүүнийг дэвшүүлэх, томилох
  - Дүрмийн санг нэмэгдүүлэх, зохистой харьцааны үзүүлэлтийг хангах ажиллах талаарх танилцуулга, төлөвлөгөө
  - Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
  - Бизнес төлөвлөгөө
  - 2023 оны санхүүгийн тайлан
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дугаар сарын 12-ны өдрөөр тогтоосугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2024 оны 03 дугаар сарын 25-ний өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр, 2024 оны 04 дугаар сарын 10-ны өдөр дахин

мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэрэгээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

- Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /Л.Гүндэгмаа/-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.
  - Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
  - Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ны агуулгыг хавсралт 2-т зааснаар баталсугай.
  - Компанийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 14 цагаар тасалбар болгосугай.
  - Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хурал зохион байгуулах бөгөөд тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- Л.Гүндэгмаа дарга
  - Б.Мөнгэрэл гишүүн
  - М.Нэргүй гишүүн

10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс-д даалгасугай.
  11. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “Монгол Секюритиес ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо , Хөрөнгийн Бирж-д хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Л.Гүндэгмаа/-д даалгасугай.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

/З.НОМУНДАРЬ /

